



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/163/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Алтай хот 2025 он	Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
ГАА-2025/163/НА-СТА-ТШЗ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	360,491.0	270,722.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,430,081.3	3,703,812.3
Нийт хөрөнгийн дүн	3,790,572.3	3,974,534.4
Нийт өр төлбөрийн дүн	1,540.0	21,362.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,789,032.3	3,953,171.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,790,572.3	3,974,534.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,814,306.8	3,661,515.4
Үйл ажиллагааны зардлын дүн	2,807,490.2	3,478,616.7
Үйл ажиллагааны үр дүн	6,816.6	182,898.7
Үйл ажиллагааны бус үр дүн	(51,498.5)	(2,561.2)
Үйл ажиллагааны нийт үр дүн	(44,681.9)	180,337.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,833,714.2	3,772,833.9
Тайлант оны үр дүн	(44,681.9)	180,337.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(16,198.3)	-
Эцсийн үлдэгдэл	3,772,833.9	3,953,171.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,700,181.2	3,182,570.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,458,413.3	3,183,297.3
Үйл ажиллагааны ЦМГ	241,767.9	(726.5)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(61,929.5)	(74,310.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	179,838.4	(75,036.5)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,612.6	191,450.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	191,450.9	116,414.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,115,601.9	3,257,408.9
Урсгал зардал	2,115,601.9	3,183,098.9
Хөрөнгийн зардал	0	74,310.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,304,209.8	3,171,163.3
Улсын төсвөөс санхүүжих	2,280,511.8	2,728,088.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих		442,825.3
Туслах үйл ажиллагааны орлого	23,698.0	250.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулсан алдаа

Аудитаар 32,952.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** "Ундарга Алтай" ААТҮГ-т 2022 онд 16,198.3 мянган төгрөгийн цэвэр бохир усны тооцоо үүссэнийг тухайн тайлант онд санхүүгийн тайланд тусгахгүйгээр 2024 оны тайлант үеийн зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т "бүх өр төлбөр"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Барилгын засварын материал дансанд биет тооллого хийхэд тайланд онд барилгад суугдсан 16,754.0 мянган төгрөгийн хаалга, цонх, цонхны шилийг бараа материалын үлдэгдлээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 97,604.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 97,604.6 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрсэнд 2 төлбөрийн акт, 4 албан шаардлага хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1. Боловсролын ерөнхий гзараас зохион байгуулсан сургалтанд амралтын өдөр хамрагдсан, 30 бүлгээс хөндлөнгийн үнэлгээ хийж үр дүнг тооцсон ажлаар 1,143.9 мянган төгрөгийн, ажилчдад тухайн сарын ажлын цагийн 10.0 хувиас хэтрүүлж 774.4 мянган төгрөгийн, цагийн тодорхойлолтгүйгээр ажилтанд 159.4 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.-т "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиаргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид зааснаас 735.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Урсгал засварын зардал 59,197.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан төсөвт өртөг бүхий урсгал засварын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай 305.5 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамнасан авлагыг барагдуулан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант жилд үүссэн гэрэл цахилгааны 5,164.6 мянган төгрөгийн, 2022 онд үүссэн цэвэр бохир усны төлбөр 16,198.3 мянган төгрөгийн, нийт 21,362.9 мянган төгрөгийн өр төлбөртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үүссэн өр төлбөрийг барагдуулан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Барилгын засварын материал дансанд биет тооллого хийхэд 13,925.9 мянган төгрөгийн бараа материал нүд үзэж тоологдоогүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.4-т "Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барилгын засварын материал дансанд биет тооллого хийж стандартын дагуу бүртгэл хөтөлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Есөнбулаг сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль	2	32.9			2	32.9	2	32.9				
Дүн	2	32.9			2	32.9	2	32.9				

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Есөнбулаг сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль	6	97.6	1	2.1	5	95.5	-	-	-	-	-	-
Дүн	6	97.6	1	2.1	5	95.5	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		